



Бурхан бол бидний Хөтөч Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол бидний Хөтөч

Attribute: God Is Our Guide

Тодорхойлолт: Тэрээр удирдан чиглүүлж, зөвлөж, замчилдаг Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Нехемиа 9:19** Та агуу энэрлээрээ тэднийг цөлд орхисонгүй. Тэдний замыг заахын тулд үүлэн багана ч өдрөөр тэднийг орхисонгүй. Тэдний явах замыг гэрэлтүүлэхийн тулд галан багана ч Шөнөөр тэднийг орхисонгүй.
- **Дуулан 23:1-3** Эзэн бол миний хоньчин, надад тутах зүйл үгүй. Ургамал ногоон бэлчээрт Тэр намайг хэвтүүлж, Усны дөлгөөн тийш Тэр намайг хөтлөн амин сэтгэлийг минь Тэр сэргээдэг. Нэрийнхээ төлөө Та Зөвтийн замаар намайг хөтөлдөг.
- **Дуулал 48:14** Учир нь энэ Бурхан мөнхийн мөнхөд бидний Бурхан. Үхэн үхтэл минь биднийг Тэр хөтөлнө.
- **Дуулал 32:8** Би явах ёстой замд чинь чамд зааварлан зааж өгнө. Нүд минь чамайг ширтэн чамд зөвлөнө.
- **Исаиа 30:21** Та нар баруун тийшээ эргэсэн ч, зүүн тийшээ эргэсэн ч, араас чинь дуугарах “Энэ бол зам. Үүгээр алхагтун” гэх үгийг чих чинь сонсоно.
- **Исаиа 58:11** Эзэн чамайг ямарт удирдан ган гачигийн үед сэтгэлийг чинь хангалуун болгож, ясыг чинь тэнхрүүлнэ. Чи усалсан цэцэрлэг мэт, ширгэшгүй устай урсгал мэт байх болно.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.* 1 Тесалоник 5:18

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Дуулал 25:9; Исаиа 58:11

Библийн эшлэлээр залбирах:

Эзэн, явах ёстой замд нь (Хүүхдийн нэр)-д замчилан заагаач. (Хүүхдийн нэр) баруун тийшээ эргэсэн ч, зүүн тийшээ эргэсэн ч, араас нь дуугарах “Энэ бол зам. Үүгээр алхагтун” гэх үгийг чих нь сонсох болтугай. Түүнийг үргэлжид замчилна гэсэн амлалт өгсөнд Тань баярлалаа!

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- Эзэн, явах ёстой замд нь _____-д замчилан заагаач. _____ баруун тийшээ эргэсэн ч, зүүн тийшээ эргэсэн ч, араас нь дуугарах “Энэ бол зам. Үүгээр алхагтун” гэх үгийг чих нь сонсох болтугай. Түүнийг үргэлжид замчилна гэсэн амлалт өгсөнд Тань баярлалаа! *Дуулал 25:9; Исаиа 58:11*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах – Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!